

РАЦИОНАЛЬ СОНГОЛТ : ОНОЛ, АРГА ЗҮЙ

Ё.Довчин

Улс төрийн ухааны доктор (Ph.D)

Улстөрийн шинжлэх ухаанд нэгэн үе ноёрхож байсан бихевиораль хийгээд бүтэц-чиг үүргийн хандлага шүүмжлэлд өртөх болсон тэр цагаас рациональ сонголтын онолтой холбоотой арга зүй улстөр судлаачид, харьцуулсан шинжээчдийн анхаарлыг татах болжээ. Рациональ сонголтын онол хэдийгээр улстөрийн шинжлэх ухаанд 50-аад оны алдад нэвтэрч эхэлсэн гэдэг ч түүнийг улстөрийн харьцуулсан судалгаанд хэрэглэх болсон нь саяхных гэж хэлж болохоор ажээ.

"Улстөрийн үйл байдлын суурь зарчмууд нь улстөрийн үзэгдлүүд, институтүүдээрээ ялгагддаг улстөрийн янз бүрийн системүүдэд ч адилхан байдаг" нь уг онолыг харьцуулсан улстөрд хэрэглэх үндэслэл болж өгч байна. Рациональ сонголтын онол арга зүйг эдүгээ өргөн ашиглах болсон учраас түүний гол гол үндэслэгээ, тэдгээрийг улстөрийн практикт хэрэглэх боломжыг нээж харуулахыг эл өгүүлэлд зорилго болгов. Рациональ шинж нь түүхэн ойлголт болох, эрдэмтэд түүний мөн чанар, хүрээ хязгаарын талаар өөр өөр үзэл бодолтой байдаг тухай товч дурдаад, дараа нь уг онол арга зүйн агуулга, үндэслэгээ, онцлогийг тайлбарлаж, эцэст улстөрийн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр, улстөрийн харьцуулсан судалгаанд хэрэглэх боломжтой зарим загваруудаас жишээ болгон авч үзсэн болно.

XX зууны эхнээс, наашлаад 70- 80-аад оноос рациональ шинж, түүний хүрээ хязгаарын тухай асуудал чухлаар тавигдах болжээ. Энэ нь үндсэндээ шинжлэх ухааны хөгжил дэх рациональ ухамсрын маргашгүй ололтуудтай холбоотой байв.

К.Мангейм шинжлэх ухаан техникийн хувьсгал, хөгжингүй аж үйлдвэрийн нийгэмтэй холбон рациональ шинжийг хоёр ялгажээ /2,с.293/. Тухайлбал, мөн чанарын рациональ шинж гэдэг нь "бодит юмс үзэгдэл, нөхцөл байдлыг ойлгохыг эрмэлзэж, энэ зорилгодоо ямар нэг хэмжээгээр хүрч байгаа сэтгэх үйлдэл" гэсэн бол чиг үүргийн рациональ шинж нь "тавьсан зорилгод хүрэхээр зохион байгуулагдсан, үүний дүнд оролцогч бүр эзэлсэн байр суурийнхаа дагуу чиг үүргийн үнэ цэнийг олж авах үйлдлүүд" ажээ. Аж үйлдвэржүүлэлт хүмүүсийг чиг үүргийн рациональ хэлбэрт захирагдахыг албаддаг учраас тэдний ихэнхийн сэтгэн бодох чадварыг доройтуулна. Иймд Мангеймынхаар "орчин үеийн сэтгэлгээний хамгийн гол шинж бол ертөнцийг бүрэн хэмжээгээр рационалчжуулахад орших ажээ".

К.Поппер рационалчжуулах нь хүрээ хязгаарт баригдахгүй гэсэн Мангеймын санааг үл зөвшөөрч "рациональ хандлагыг хүлээн зөвшөөрөхийг хүсэхгүй байгаа хүнд ямар ч рациональ үндэслэлүүд рациональ байдлаар нөлөөлж чадахгүй" гэсэн нь тэрбээр хувь хүнд сонголт хийх боломжыг үлдээсэн хэрэг /3, с.267/.

К.Хюбнер рациональ шинж нь зөвхөн шинжлэх ухааны талд байдаг гэдэг нь эргэлзээтэйг /5,с.220/ тэмдэглээд, ухамсрын иррациональ хэлбэр болох домог ч шинжлэх ухааныхаас өвөрмөц өөрийн рациональ шинжтэй болохыг нотолсон байдаг.

Ийнхүү рациональ байдал нь үе үеийн судлаачид янз бүрээр тайлбарлаж ирсэн түүхэн шинжтэй ойлголт юм. Рациональ шинж, түүний хүрээ хязгаарыг шинээр ойлгох шаардлага рациональ сонголтын онолын төлөөлөгчидтэй холбоотой байв. Эдийн засгийн шинжлэх ухаанд "эдийн засгийн хүн"-ий рациональ үйл байдлын загваруудыг өргөн хэрэглэх болжээ. Энэ утгаар рациональ шинж гэдэг нь хамгийн чухал зорилго, үр дүнд хүрэх үйл байдлын тодорхой чиг шугамуудыг сонгон шалгаруулахад орших ажээ. Судлаачид рациональ шинжийг бүхэлд нь хувь хүн тодорхой аргуудыг хэрэглээд олж хүртэх ашиг тусаа жишиж харьцуулах арга хэрэгсэл талаас голдуу ойлгож хандаж байсныг дурдах хэрэгтэй. Энэхүү чиглэл М.Веберын үзэл баримтлалаас эхтэй гэдэг бөгөөд тэрбээр рациональ шинжийг хамгийн ашигтай үйл байдлын эдийн засгийн тооцоотой эн тэнцүү үзэж байв. Сонгодог эдийн засгийн онол рациональ үйл байдлын энэ загварын хүрээнд хөгжиж байсан ч яваандаа рациональ ойлголтыг ингэж хэт явцуу үзэж болохгүй нь тодорхой болжээ.

Энэ нөхцөлд удирдах үйл ажиллагааг "хатуу" рациональ шинжтэй адилтгаж, формаль биш, чанарын, агуулгын шинжтэй хэмжигдэхүүнүүдийг гадна үлдээн, бүх шийдвэр гагцхүү дээр дурдсанаар хатуу аналитик байдлаар үндэслэгдэх ёстой байв. Тухайн үеийн рациональ сонголтын онолчид аж ахуйн дотоод нөөцийг хэрхэн зүй зохистой зохицуулахад илүүтэй анхаараад гадаад орчин, тухайлбал, "хүний хүчин зүйлийг" орхигдуулж байжээ. Гэвч цаашдаа хувь хүмүүсийн үйл байдлын стратегийг системтэй судалснаар "рациональ хувь хүний" үйл ажиллагааг гадны хүчин зүйлсийн нөлөөлөлтэй холбон авч үзсэн шинэ чиглэл улстөрийн онолд гарч ирсэн байна. 90-ээд оны эх гэхэд нийгмийн амьдралыг онолын талаас судлах ерөнхий хандлагын хувьд рациональ сонголтын онолын нөлөө улам нэмэгдсэн аж. Нийгмийн үзэгдлүүдийн формальчлал, математик загварчлалын боломж энэ онол хөгжих нэг шинэ эх сурвалж болжээ.

"Эдийн засгийн хүн"-ий загвар нь бодит амьдрал дээр ашгаа дээд зэргээр нэмэгдүүлэх зорилгоор боломжит бүх хувилбаруудаас хамгийн сайныг нь сонгох төгс рациональ шинжийг хувь хүнээс шаарддагаараа онцлог аж. Гэвч ялангуяа удирдлагын шинжлэх ухааны хөгжлийн явцад уул загвар бодит байдалд төдийлөн нийцэхгүй байгаа нь илэрхий болсон байна. Хүний сэтгэхүй, үйл байдалд рациональ бус элементүүд үлэмж байдгийг анхаарах хэрэгтэй болсон. Америкийн эрдэмтэн Г.Саймон хүний рациональ чанар амьдрал дээр хязгаарлагдмал байдгийг нотолж, "эдийн засгийн хүн"-ий оронд "засаг захиргааны хүн"-ий загварыг санал болгосон байна. Хэрэв "эдийн засгийн хүн" байгаа хувилбаруудаас хамгийн төгс сайныг нь сонгодог бол "засаг захиргааны хүн" боломжийн, эсвэл хангалттай гэсэн сонголтыг эрэлхийлж байдаг ажээ. Баараггүй нарийн тооцсон хувилбаруудыг гагцхүү онцгой тохиолдлуудад л сонгож авах хэрэгтэй. Шийдвэр гаргах нь ихэнхдээ боломжийн хувилбаруудыг онож сонгохтой холбоотой бөгөөд өөрөөр хэлбэл, боломжийн бүх хувилбарыг эрж хайхгүйгээр амьдралын ухааны харьцангуй энгийн зарчмуудыг ашигладаг гэсэн үг. Чингэхдээ "дээд зэргийн ашгийг" бус, "боломжийн ашгийг", "ашиг тооцсон үнийг" бус "шударга үнийг" урьдал болгоно.

Саймоны онолд үндэслэн Д.Марч, Д.Олсен нарын судлаачид ямарч хүний хувьд анхаарал, ой тогтоолт зэрэг нь голдуу хомсдолтой нөөц байдгаас үүдэн рациональ шинж танин мэдэхүй талаас хязгаарлагдмал байдгийг батлаад үүний дээр хүний үнэлэмж баримжаа, тэдгээрийн хувирамтгай шинжийг харгалзах хэрэгтэйг тэмдэглэдэг байна. Түүнчлэн тухайн этгээдийн сонголт бусдынхтай зөрчилдсөнөөс рациональ шинжийн улстөрийн хязгаарлалт гарч ирдэг байна. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн хязгаарлалт улстөрийн хязгаарлалттай давхцаж байгаа хэрэг. Иймээс аливаа байгууллага тодорхой рациональ чанарыг гэхээсээ хэлцэл тохироог илүүд үзэх нь бишгүй тохиолддог нь үүнтэй холбоотой ажээ.

Бихевиорализм, бүтэц-чиг үүргийн хандлага хямралд орсон 50-аад оны үеэс рациональ сонголтын онол эдийн засгаас улстөрийн шинжлэх ухаанд нэвтэрч орж иржээ. Э.Даунс анх рациональ сонголтын онолыг улстөрийн судалгаанд, түүний дотор ардчиллын үзэл баримтлалыг боловсруулахад хэрэглэсэн байна. Түүний ардчиллын эдийн засгийн загвар улстөрийн үйл байдлын рациональ шинж дээр тулгуурлаж, улстөрийн субъект бүр /сонгогч, намын ажилтан, засгийн газрын гишүүн, тэр ч атугай байгууллага бүхэлдээ/ үйл ажиллагааныхаа үр дүнг эдийн засгийн утгаар ашигтай байлгахыг, өөрөөр хэлбэл бага зардлаар илүү үр дүнд хүрэхийг эрмэлздэг гэж үзсэн байна. Түүнийхээр рациональ үйл байдал урьдчилан таамаглах бололцоо олгож, үнэлэмж баримжааг эмхэлж цэгцэлж, үнэлж цэгнэж байдаг. Улстөр бол өрсөлдөөн, арилжаа солилцоо өрнөж байдаг зах зээлтэй утга дүйнэ. Иймээс рациональ сонголтын онол ёсоор ардчиллын нөхцөлд засгийн газар бүр улстөрийн дэмжлэгээ дээд зэргээр нэмэгдүүлэхийн төлөө тэмцэж байдаг, нөгөө талаас иргэн бүр үйлдлийнхээ үр дүнгийн ашиг тусыг дээд зэргээр нэмэгдүүлэхийг хичээж байдгийг тэрбээр чухалчлан үзсэн байна /7, р.11,37/. Үүнээс үндэслэн ардчилсан системн онцлог нь удирдагч нар нь ч, удирдуулагч нар нь ч хийсвэр үнэт зүйлсийг биш, харин өөрийн бодит ашиг сонирхлыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулдаг орших ажээ. Энэ нь цаад утгаараа улстөрийн аливаа субъектын үйлдэл нэг талаас эгоист, нөгөө талаас рациональ шинжтэй байдгийг тодотгож өгч байна.

Рациональ сонголтын онол харилцан үйлчлэл, харилцан солилцоог товойлгон үздэгээрээ ялгардаг бөгөөд тоглогчид хоорондоо харилцан үйлчилж, тэгэхдээ бүр хамгийн рациональ, эсвэл

эгоист гэмээр үйл байдал үзүүлж байсан ч тэдгээр нь чухам ямар стратеги сонгон авснаасаа шалтгаалан хожиж, эсвэл хожигдох болно. Рациональ сонголтын онолын давуутай тал нь хүмүүсийн үйл ажиллагааны тоо томшгүй олон талт байдлыг тодорхой тооны хялбарчилсан загваруудад оруулж, тэдгээр нь тухайн субъектүүдэд тохирох стратегийг тодорхойлж өгч байдагт оршино /1, с.20/. Стратеги нь хамтын ашигтай, хувийн ашигтай гэж хоёр янз байж болох ба эцсийн зорилго нь хамтын ашигтай стратегийг субъектүүдээр сонгуулах явдал юм. Тухайлбал, үүнийг "хоригдлын дилемм" загвар /1, с.21-22/ тодорхой харуулдаг. Уг загварыг 70-80 -аад оны үед олон улс хоорондын томоохон зөрчлүүдийг шижлэхэд улстөр судлаачид өргөн ашиглаж байжээ.

Рациональ сонголтын онол улстөрийн судалгааны тэргүүн шугамд өөрийн гэсэн ашиг сонирхол, хэрэгцээ бүхий, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хүнийг гаргаж тавьснаараа өмнөх арга зүйгээс ялгаатай байв. Тухайлбал, бүтэц-чиг үүргийн хандлага системүүд, бүтцүүд мэтийн ойлголтуудад анхаарал төвлөрүүлснээс хүн бие дааж сэтгэж, үйлдэл хийдэг субъектын хувьд бүдгэрэн, хэрэг дээрээ нийтийн жишгээс гаждаггүй номой дорой "нийгмийн амьтан" болж хувирчээ. Харин рациональ сонголтын онол хэм хэмжээг тогтоодог, тэдгээрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, өөртөө ашигтай үйл байдлыг сонгон авч байдаг хувь хүний идэвхтэй үүргийг баримжаа болгосон байдаг. Энэ утгаараа уг онол "социологийн хүн"-ийг зорилготой, ашиг сонирхлоо гэсэн "эдийн засгийн хүн"-ээр сольсон гэсэн үг юм.

Бихевиораль арга зүй улстөрийг шинжлэх ухааны үүднээс судлахад нэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тооцоо судалгаа, хэмжилт, тов тодорхой нотолгоо, таамаглалуудыг оруулж ирсэн гэж болно. Улстөрийн институтүүдийг зураглан тодорхойлохоос хэтрэхгүй байсан урьдын уламжлалыг халсан. Ер нь бихевиоралистууд ихэнхдээ институтүүдийг хувь хүний роль, статус, үнэт зүйлсийг орлосон бүрхүүл мэтээр ойлгож байв. Тэд хувь хүний үйл байдлыг төвд тавьж, энэхүү үйл байдал тухайн үеийн парадигмд дасч зохицож байх ёстой гэж үзэж байв. Бихевиораль онол хувь хүний үйл байдлыг авч үзэхдээ ролиуд, статус, гадна орчинд өгөх хариу үйлдлийг судлахад тулгуурлаж байсан бол рациональ сонголтын онол үнэлэмж баримжаа, эсвэл мөрдлөг болгодог үнэт зүйлсийг үндэслэдэг байна. Рациональ сонголтын онолыг баримтлагчид зөвхөн үйл байдлыг бүхний дээр тавьж сонголтыг тайлбарлах нь хэт хийсвэр гэж үзээд үүний зэрэгцээ бүтцийн онцлог шинжүүд, дэг горимын асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх нь чухал гэсэн санаа дэвшүүлсэн байна. Өөрөөр хэлбэл нийгмийн үзэгдлийг тайлбарлахдаа агентын үнэлэмж, үйл байдлыг нарийн цэгнэх төдийгүй институциональ онцлогийг харгалзан үзэх ёстой гэсэн үг байв. Энэ утгаар рациональ сонголтын онол институционализм руу буцаж эргэсэн гэж болно. Гэхдээ улстөрийг нэгэн норматив систем гэж тодорхойлж, түүнийг үндсэн хууль, эрх зүйн ойлголтоор авч үздэг, үүнээс үүдэн хуулийн хэм хэмжээтэй зөрчилдөж байдаг улстөрийн бодит байдлыг орхигдуулдаг хуучин институционализмыг хүлээн аваагүй байна. Формаль-легаль шинж давамгайлсан уламжлалт институционализм хэм хэмжээг идеалчилсан нь нийтийн эрх ашгийг бас ийм байдалд хүргэж, үүнээс болж тодорхой хүмүүсийн хувийн ашиг сонирхол гадна үлдэж байжээ. Харин рациональ сонголтын онол хувь хүний үйл байдал, институтүүдийн хоорондын харилцааг шүтэлцээтэй авч үзэж, тэр дундаа хүний үйл байдлыг өөрийн ашиг сонирхол бүхий идэвхтэй агентын өнцгөөс харж үзүүлснээрээ онцлог байдаг.

Д.Като хувь хүний рациональ шинжийг институциональ анализын чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг, эсвэл үүнийг үгүйсгэдэг хандлагуудыг үндэслэн неоинституционализмыг нийгэм-түүхийн, рациональ сонголтын гэж ялгаж авч үзсэн байна /8/. Энэ хоёр чиглэл институтүүд хэрхэн улстөрийн үйл байдал, үр дүнг бий болгодог асуудлыг хөнддөгөөрөө нийтлэг хэдий боловч ялангуяа институтүүд доторхи хувь хүмүүсийн үйл байдлыг задлан ялгах, тайлбарлал хийх аргаараа ялгавартай аж. Хэрэв нийгэм-түүхийн судалгаа институтыг анализын анхдагч судлах зүйл гэж үздэг бол рациональ сонголтын арга зүй хувь хүний рациональ үйл байдалд анхаарал төвлөрүүлж энэ нь институтүүдтэй хэрхэн харилцан шүтэлцээтэй байдгийг судалж шинжилдэг байна. Рациональ сонголтын неоинституционализмын шинэлэг тал нь үр дүн, нөлөөллийг шинжлэх, түүний дотор хэний ашиг сонирхол, эсвэл үнэлэмж төрийн бодлого, нийгмийн шийдвэрүүдэд зонхилж буйг задлан ялгалахад оршино.

Катогийн үзсэнээр нийгэм-түүхийн неоинституционализмыг дотор нь төр төвтэй судалгаа, институтыг бүрдүүлэгч суурь элементүүдэд /загварууд, дүрэм журам, хэм хэмжээнүүд, үнэт зүйлс, үзэл санаа/ тулгуурласан судалгаа гэж ангилж болох ажээ. Жишээ нь, төр төвтэй судалгаа "нийгэм-төр" гэсэн харилцааг шинжилж, төрийн автономи /төр нийгмийн дарамт шахалтаас ямар хэмжээгээр хамаарч байдаг/, төрийн чадвар /улстөрийн бодлого, улстөрийн өөрчлөлтөд төр ямар хэмжээнд нөлөөлж байдаг/ гэсэн асуудлыг нарийвчлан авч үзсэн байдаг /9/ бол хоёрдахь чиглэл "төр-нийгэм" харилцааг судалж, төр ба нийгмийн харилцан үйлчлэлийн бүтцүүдийг тодруулж, эдгээр нь улстөрийн бодлого, өөрчлөлтүүдтэй хэрхэн уялдаж байдгийг нээж харуулахад чиглэдэг байна. Гэвч неоинституционализмын хоёр чиглэлийн ялгааг туйлшруулах нь зохисгүй гэж үздэг. Тухайлбал, улстөрийн үр дүнг тайлбарлахад институтэд биеллээ олсон дүрэм журам, хэм хэмжээ мэтийн хүчин зүйлсийг хувь хүний рациональ тооцооны дүрэмтэй хамт ашиглах бололцоо байдаг. Түүнчлэн нийгэм-түүхийн хандлага институтүүдийн үүслийг тодорхой хэм хэмжээг хүлээн авсны болон түүхэн нөхцөл байдлын үр дүн гэж үздэг бол рациональ сонголтын арга зүй тэдгээрийн үүслийн рациональ үндсийг гол болгодог байна. Мөн нийгэм-түүхийн хандлага рациональ үйл байдлын угтвар үндэслэлийг агуулж байж болно. Жишээ нь, рациональ шинж этатист хандлагын маргаангүй нэг хэсэг нь болдог. Үүнийг юуны өмнө албан тушаал дээр байгаа, төрийн алба хаших сонирхолтой албан хаагчдад хамааруулан үзэж болох юм.

Рациональ сонголтын онол хэд хэдэн түлхүүр ойлголтод тулгуурладаг гэж болно. Юуны өмнө уг онол ёсоор улстөр бол хүмүүс хоорондын *арилжаа солилцооны* нарийн нийлмэл систем буюу нэг үгээр хувь хүмүүсийн *харилцан үйл ажиллагаа* юм. Хувь хүн нийгэм дотор өөрөө ганцаараа үйл ажиллагаа явуулдаггүй учир бусад хүмүүс ч рациональ үйл байдлын алхам хийнэ гэдгийг тооцож байдаг. Хүмүүс чөлөөтэй харилцаж хамтран ажиллах / хамгийн анхдагч тохиролцоо/ дээр санал нэгдсэн тул сонголтууд нь харилцан хамааралтай байхаас аргагүй. Мэдээж хувь хүн өөрийн ашгийг дээд зэргээр нэмэгдүүлэхийг хичээх боловч уул зорилгоо тодорхой нөхцөлд гүйцэлдүүлэх хэрэгтэй болно. Өөрөөр хэлбэл хүмүүс рациональ сонголтыг институциональ нөхцөлд хийдэг гэсэн үг.

Субъектын рациональ үйл байдал, институтын харилцан холбооны талаар ялгаатай байр сууриуд байдаг ч хоёр асуудлыг иш үндэс болгодог байна. Нэг талаас институциональ бүтцүүдийн хүрээнд ашиг сонирхлоо урьдал болгосон хувь хүмүүс тэдгээрт дасч зохицохоосоо тэдгээрийг ашиг сонирхлынхоо дагуу өөрчлөхийг оролдож байдаг. Нөгөө талаас институциональ бүтцүүд, ашиг сонирхлын хооронд харилцан үйлчлэл байдаг. Тухайлбал, хувь хүмүүс институтүүдийг өөрчлөхийг оролдож, харин институтүүд үнэлэмжийн эрэмбэ дарааллыг өөрчилж болно.

Өөр нэг тулгуур ойлголт нь *хувь хүн* бөгөөд рациональ сонголтын онол хувь хүний үйл байдлыг арга зүйн үндэс болгож судалгаа шинжилгээг институтээс биш, харин идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хувь хүнээс эхэлдэг. Учир нь нийгэм, институтүүд хувь хүнтэй харьцуулахад хоёрдугаар зэргийн бөгөөд гагцхүү хувь хүн өөрийн үйл ажиллагаагаараа институтүүд, харилцааг бий болгодог. Рациональ сонголтын онол хувь хүмүүсийн ашиг сонирхол угаас тэдэнд өгөгдсөн байдаг, ашиг сонирхол, зорилгыг гаднаас тулгаж чадахгүй, эцсийн бүлэгт яахаа хувь хүн өөрөө шийддэг гэдгийг иш үндэс болгодог.

Хувь хүмүүсийн рациональ шинж рациональ сонголтын онолын үндсэн ойлголт мөн. Хувь хүн боломжтой бүх нөхцөлд ашгаа нэмэгдүүлэхийг мэрийж, рациональ үйлдэл хийхийг үргэлж эрмэлзэж байдаг. Хувь хүн үнэлэмж, үзэл бодолтой байж, үнэт зүйлсээ тодорхой эрэмбээр байршуулан өөртөө ашигтай сонголтоо хийж үйл ажиллагаа явуулна. Гэхдээ хэн нэгэн эрхэм дээд үзэл санааны тухай юмуу аль эсвэл адгийн муу хүсэл шуналын талаар ярилаа ч ашиг сонирхолдоо хөтлөгдөх явдал эцсийн бүлэгт гол төлөв хүмүүсийн үйл байдалд бодитой нөлөөлдөг гэж рациональ сонголтын онол тооцдог. Гэвч энэ нь хүн заавал хувиа хичээх ёстой гэсэн үг бас биш бололтой. Хүн альтруист үйл байдал гаргаж болно, хамгийн гол нь уг үйл байдлын хувийн ашиг тус чухам юунд байгааг ойлгоход л оршино гэж Даунс тэмдэглэсэн байна. Нөгөө талаар томоохон хамт олон, хэсэг бүлгүүдийн доторхи хувь хүн тэдгээрийн бус, харин мөн л өөрийн ашиг сонирхлоо урьдал болгодог нь рациональ шинжтэй ямар нэг шижмээр холбогдож болох юм. Нэг үгээр хамтын баялгаас дуртайяа авч хэрэглэх

боловч түүнийг бүтээхэд тэр бүр сайн дурын идэвх санаачилга гаргахгүй, харин ч нийтийн үйлчилгээнээс үнэ төлбөргүй хувь хүртэхээр тэмүүлэх нь цөөнгүй ажээ /”туулайчлах” асуудал/. Хүний үйл байдлын рациональ шинжийг мэдээлэл сайн байхтай холбож үздэгийг бодолцох ёстой.

Рациональ сонголтын онолын бас нэг чухал элемент нь *ашигаа цэгнэсэн үйл байдал* /оптимизаци/ юм. Рациональ үйл байдал зарим утгаараа оптималь сонголтын тухай асуудал юм. Энэ нь заримдаа ашгийг тэргүүн зэрэгт тавих, эсвэл өртгийг дээд зэргээр бууруулах зэргээр илэрч, үйлдлийг гарах үр дүнтэй жишиж харьцуулах, хамгийн өндөр үр дүнтэй хувилбарыг сонгон авах бололцоо олгох ач холбогдолтой байдаг ажээ.

Ийнхүү рациональ сонголтын онол *нэгдүгээрт*, өөрийн гэсэн ашиг сонирхол бүхий хувь хүний идэвхтэй үүрэг ролийг судалгааны төвд тавьж, хувь хүний хийгээд нийт нийгмийн асуудлаар шийдвэр гаргахад хувь хүний бие даасан байдлыг хадгалах үүднээс хувийн үйл байдал, нийгмийн институтүүдийг холбож өгөх боломжыг нээж өгсөн байна.

Хоёрдугаарт, рациональ сонголтын онол эдийн засгийн үйл байдлыг улстөр дэх хүний үйл байдалтай адил төсөөтэй гэдэгт судлаачдын анхаарлыг хандуулж засаглал хийгээд шийдвэр гаргах хүрээнд хүн эдийн засгийн амьдралд оролцогчийнхоо нэг адил рациональ ханддаг гэдгийг үндэслэсэн байна. Улстөрийн үйл ажиллагаа, улстөрийн байгууллагуудыг үр ашгийн хэмжүүрүүдээр авч үзэх нь улстөр дэх хувь хүний рациональ шинжтэй холбоотойг нотолсон.

Гуравдугаарт, рациональ сонголтын онол, ялангуяа түүнийг харьцуулсан улстөрд хэрэглэж эхэлсэн нь улстөрийн хавсрал судалгаа, түүний практик ач холбогдлыг мэдэгдэхүйц өргөж өгсөн байна. Улстөрийн тоглоом, эвсэл хэлэлцээ байгуулах, сонгуулийн стратеги, эрх мэдлийн хуваарилалт, улстөрийн конфликтологи зэрэг рациональ сонголтын судлалын хэсгүүд улстөрийн зөвлөгөө, менежментийн үр нөлөөтэй арга хэрэгсэл болж өгчээ.

Төгсгөлд нь харьцуулсан улстөрд рациональ сонголтын онолыг хэрэглэсэн нэг жишээг толилуулья. Энэ бол эвсэл байгуулах загвар бөгөөд түүнийг олон намаас бүрдсэн парламентын системтэй, нам тус бүрдээ бие дааж засгийн газраа байгуулах, улстөрийн шийдвэрийг санал хураалтаар батлах боломж хязгаарлагдмал улстөрийн системд гол төлөв хэрэглэдэг байна.

Эвсэл байгуулах загваруудыг ерөнхийд нь хоёр бүлэгт хувааж болно. Нэгдэх нь эвслийн тоон үзүүлэлтэд тулгуурладаг, хоёрдахь нь эвсэлд оролцогчдын улстөрийн байр суурь ойролцоо төсөөтэйг шалгуур болгодог ажээ. Энэ бүхнийг 1983 оны сонгуулийн дүнд байгуулагдсан Исландын жишээн дээр /хүснэгтээс үз/ судлаачид /6/ авч үзсэн байдаг. Учир нь уул кейс хэд хэдэн хэмжигдхүүнээрээ тохиромжтой байжээ. Үүнд: парламент нь цомхон /60 гишүүнтэй/, намын тоо хангалттай /6/, суудлын тоо нь тооцоход хялбар, эвсэл байгуулсан үр дүн тодорхой г.м.

Хүснэгтэд намуудыг улстөрийн байр сууриар нь "зүүн-баруун" гэсэн хуваариар байрлуулсан. Чингэхдээ Дэвшлийн нам төв намын үүрэгтэйг харгалзжээ. Нам бүрийг үсгээр тэмдэглэж, мөн боломжит эвслүүдийг бас үсгээр заасан байна.

Тухайлбал: "*Ялахад хангалттай эвсэл*" -ийн үндэс нь Рикерийн эвслийн "хэмжээний зарчим" болдог. Улстөрийн намууд олонхи болохыг эрхэмлэдэг гэсэн Даунсын зарчмын оронд Рикер эвсэл байгуулахдаа улстөрийн намууд ялахад л хангалттай саналаас илүүг авах гэж эрмэлздэггүйг нотолсон байна. Эрх мэдлээ нэмэгдүүлэх хүсэл нь эвслээрээ "бялууг" хуваах үед бага зардал гаргах прагматик санаагаар хязгаарлагддаг ажээ. Эвсэл том байх тусам оролцогч нэг бүрт ногдох эрх хэмжээ багасах нь ойлгомжтой. Энэ загвар эвслээс аль нэг нам гарахад ялах магадлалаа алдаж байдгаараа онцлог юм.

Исландын жишээн дээр ялах боломжтой эвсэл 30-аас доошгүй гишүүнтэй, бүх намууд засгийн газрын эвсэлд орохыг эрмэлзэж байгаа гэж үзвэл дараах эвслүүд байх аж. Үүнд: АВГД – 31, АБЕ – 33, БВЕ – 32, АБГД – 34, ГЕ – 33, ДЕ – 37 тус бүр суудалтай байна. Бүх эвсэл шийдвэр батлах бололцоотой, нэмэлт хүч шаардлагагүй байна. Уг загвар парламент дахь хүчний хуваарилалтын талаар прогноз хийх боломж олгодог ч дурдсан эвслүүдээс чухам аль нь хамгийн бодитой вэ гэдэгт хариу өгч чаддаггүй аж.

Хүснэгт.Исландын парламент дахь намуудын байж болох эвслүүд* (1983 оны сонгууль)

Намууд :	Социал демократуудын холбоо	Социал демократ нам	Эмэгтэйчүүдийн холбоо	Ардын холбоо	Дэвшлийн нам	Бие даасан нам
	А	Б	В	Г	Д	Е
←					→	
Парламент дахь суудал:	4	6	3	10	14	23 60

Загварууд:

"Ялахад хангалттай эвсэл"	АВГД	АБЕ	БВЕ	БВГД	АБГД	ГЕ	ДЕ
"Эвслийн доод хэмжээ"	АВГД						
"Хэлцлийн теорем"	ГЕ	ДЕ					
"Бага орон зай"	ДЕ						
"Ойр холбоотой эвслүүд"	БВГД	ДЕ					

* Эх сурвалж: Dick, Natkeil, 1986, p. 66.

Энэ асуултад хариу өгөхөд эвслүүдийн рациональ шинжийг үнэлэх нэмэлт шалгуурыг хэрэглэдэг "Эвслийн доод хэмжээний" загвар тусална. Үүний мөн чанар нь өөр хоорондоо эрх мэдлийг зааглах талаар эвслүүдэд оролцогчдын харьцаа юм. Энэ тохиолдолд оролцогч бүр эвсэл дотор өөрийн эрх мэдлийг дээд зэргээр нэмэгдүүлэхийн тулд хамгийн бага тооны оролцогчтой эвсэл байгуулахыг хичээдэг. Д нам байж болох 4 эвсэлд оролцогч бөгөөд түүний 14 суудал илүү жин дарах тэр л эвслийг сонгох болно. Хэрэв шийдвэр батлахад түүний суудлын хувь ач холбогдолтой гэвэл тус нам 45 хувийн нөлөөлөлтэй АВГД эвслийг сонгоно. Энэ хувь 42 байгаа учраас БВГД эвслийг сонгохгүй нь лав. Г нам мөн оролцогчдын тоогоор ойролцоо хэр нь 30 хувийн нөлөөлөлтэй БВГД, ГЕ эвслүүдийг биш, харин 32 хувийн нөлөөтэй АВГД эвслийг сонгоно. А, В намууд мөн иймэрхүү байдлаар эвсэх болно. Ийнхүү "эвслийн доод хэмжээний" загвар ёсоор бол нийт эвслүүдээс эвсэлд оролцогчдын тоо нь 31 болсон ердөө ганцхан хувилбар АВГД боломжтой байна.

"Хэлцлийн теорем" загварт хамгийн гол нь эвсэлд оролцогчдын тоо бус харин эвсэл байгуулж буй намуудын тоо чухал юм. Энэ нь эвслүүдийг бүрдүүлэх, хадгалахад шаардагдах зардлыг багасгахтай холбоотой бөгөөд намуудын тоо олон байвал хэлцлийн талаар тохиролцох, бүрэн гүйцэд мэдээлэл авах, гэрээ хэлэлцээр хийхэд бэрхшээлтэй байдаг нь ойлгомжтой. Эвсэлд багтсан намуудын тоо цөөн байх тусам зохицох чадвар сайн, илүү бат бэх байна. Эдгээрт үндэслэн "ялахад хангалттай эвслүүд"-ээс хамгийн "хямд" эвслүүдийг сонгон авах болж байна. Сонгож авсан жишээн дээр бол тэдгээр нь ГЕ, ДЕ болно.

Дараах хоёр загвар эвслүүдийн хэмжээг шалгуур болгоод зогсохгүй тэдгээрт оролцогчдыг "баруун-зүүн" улстөрийн хуваарь дээр байршуулахыг гол үзүүлэлт болгодог. Эвслийн шинж чанар ихэвчлэн улстөрийн үзэл бодол, намуудын хөтөлбөрийн ойролцоо байдлаар тодорхойлогдож байдаг нь эвсэл байгуулах үйл явцыг хөнгөвчилж өгдөг. Өөрөөр хэлбэл, энэ нь эвслийг илүү "хямд төсөр", илүү бат бэх болгодог учраас рациональ хэмжүүрт тохирч байна.

"Бага орон зайн" загварын хувьд эвсэл байгуулах шалгуур нь "баруун-зүүн" хуваариар намуудын хоорондоо ойр дөт байршил болдог. Тодруулбал, намуудыг зааглаж буй зай гол үзүүлэлт юм. Зааглаж буй орон зайнуудын тоо бага намууд эвсэхэд дөхөмтэй байна. Хүснэгтээс үзэхэд энд 5 орон зай байна. АВГД эвсэл -4, АБЕ-5, БВЕ-, БВГД-3, АБГД-4, ГЕ- 2, ДЕ- 1 зааглагч орон зайтай байна. Бүх боломжит эвслүүдээс "бага орон зайн" шалгуурт нэг зааглагч орон зайтай ДЕ эвсэл тохирч байна. Намуудыг хуваарь дээр зөв онож байрлуулахаас эхлээд уг загварыг хэрэглэхэд

төвөгтэй байдлууд гарч болохыг үгүйсгэхгүй ч энэ нь загварын практик ач холбогдлыг бууруулах аргагүй байдаг.

"*Ойрын холбоотой эвсэл*" загвар нь тоон шалгууруудыг чанарынхаар тодотгож өгдөг. Эвслийн боломжит оролцогчдыг нэг шугаман хуваарь дээр "зүүнээс баруун" тийш байрлуулдаг. "Бага орон зай" загвараас ялгаатай нь намууд зааглагч орон зайг "алгасч харайх" биш, харин хуваарь дээр хамгийн ойр орших хөршүүдтэйгээ эвсэл байгуулдаг. Хэрэв аль нэг нам эвсэл байгуулах бололцоотой түншүүдийн дунд орчихвол тэр нь тэдэнтэй эвсэх магадлал өндөр байдаг. Энэ нь илүү намыг хүлээж авч байгаа ч биш юм. Эвсэл гишүүдийн тоогоо ялалт байгуулах хэмжээнд л барьж байхыг эрмэлзэх боловч бас намуудын хоорондох шууд холбоо сүлбээг тооцон үзэх хэрэгтэй болдог байна. Жишээн дээр БВГД, ДЕ эвслүүд "ойрын холбоотой" эвслүүд болж байгаа нь ажиглагдана.

Хүснэгтээс харахад эвсэл байгуулах загваруудыг хэрэглэж дэвшүүлсэн таамаглалууд ялгаатай болох нь илт байна. "Ялахад хангалттай эвслийн" загвараас бусад бүх таамаглалуудад хувилбаруудын тоо хязгаарлагдмал байгаа ч ДЕ эвслийн хувилбар онолын шалгууруудаар батлагдаж байна гэх үндэстэй байна. Үнэхээр 1983 онд Исландад байгуулагдсан засгийн газрын эвсэл баруун төвийн Дэвшлийн нам ба Бие даасан намаас бүрдэж байжээ. Жишээн дээр энэ нь Д ба Е намууд юм.

Улстөрийн шинжлэх ухаанд эвслүүд байгуулах загварууд хэр зэрэг үнэн зөв эсэх талаар асуудал дэвшигдэж, энэ талаар судалгаа ч хийгдсэн байдаг. Янз бүрийн орнууд дахь эвслүүдийн харьцуулсан судалгаа эдгээр загварууд нэлээд бодит үндэслэлтэй таамаглал дэвшүүлдэг болохыг баталсан ажээ. Тухайлбал, А.Лейпхарт 21 ардчилсан оронд 1945-1980 онуудын хооронд янз бүрийн эвслийн үндсэн дээр байгуулагдсан засгийн газруудын оршин тогтносон хугацааг харьцуулан судалсан байна. Судалгааны дүнгээс үзэхэд дайны дараах дэглэмийн оршин тогтносон хугацааны 59 хувьд "ялахад хангалттай эвслүүд"-ийн үндсэн дээр байгуулагдсан засгийн газрууд удирдаж байсан ажээ. Энэ бүхнээс үндэслэн дүгнэхэд рациональ сонголтын онолд өөр өөр байр сууринаас шүүмжлэлтэй хандаж болох хэдий ч түүний гол ололт нь тодорхой нөхцөлд улстөрийн үйл явцыг загварчлах, эдгээр загваруудыг анализын арга хэрэгсэл болгон ашиглах бололцоо олгосонд оршдог гэж болох юм.

Ном зүй

1. Голосов Г. Сравнительная политология. Новосибирск. 1995.
2. Мангейм К. Диагноз нашего времени. М., 1994.
3. Поппер К. Открытое общество и его враги. Т.2. М., 1990.
4. Фармер М. Рациональный выбор: теория и практика // Полис. 1994. № 3.
5. Хюбнер К. Истина мифа. М., 1996.
6. Dick L., Natkeil R. World Atlas of Elections: Voting Patterns 39 Democracies. The Economist Publications, London, 1986.
7. Downs A. An Economic Theory of Democracy. N-Y., 1957.
8. Kato J. Institutions and Rationality in Politics // British Journal of Political Science. 1996. Vol.26, N 4.
9. Skocpol T. Bringing the State Back In: Strategies of Analysis in Current Research.